



СОЁМБО МЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№207 /417/

2022.11.16

Цаг үе, үйл явдал

БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧИН АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС АНГИД БАЙХ ТАЛААР УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА



Батлан хамгаалах яам нь Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон УИХ-ын 2016 оны тогтоолоор батлагдсан “Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллаж буй билээ. Энэ хүрээнд Авлигатай тэмцэх газар, Батлан хамгаалах яамны ёс зүйн зөвлөлтэй хамтран тус яамны харьяа байгууллагууд, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын бие бүрэлдэхүүнтэй “Авлига түүний нөхцөл, шалтгаан, авлигын хор уршиг” сэдвээр сургалт, соён гэгээрүүлэх өдөрлөгүүдийг өнгөрсөн хугацаанд амжилттай зохион байгуулсан. Түүнчлэн Батлан хамгаалах салбарын шударга байдлын үнэлгээг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр Авлигын эсрэг хамтарсан төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Тэгвэл энэ удаад Батлан хамгаалахын сайдын өгсөн үүргийн дагуу салбарын хэмжээнд авлига, ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой сургалтыг өнөөдөр ҮБХИС-ийн “Сүбээдэй” танхимд болон цахимаар зохион байгууллаа. Зэвсэгт хүчний Жанжин штаб, ХЗЦК, АЦК, ТХЦК, КАБЦК, Барилга-инженерийн цэргийн удирдах газар болон харьяа нэгтгэл, анги, салбаруудын алба хаагчид хамрагдсан тус сургалтыг Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар

нээж үг хэлэв.

Тэрээр “Батлан хамгаалах яамны Ёс зүйн зөвлөлөөс 2022 оныг “Зөв харилцаа, хандлагын жил” болгосон. Энэ хүрээнд Батлан хамгаалахын сайдын хувьд офицер, ахлагч нарт хоёр зүйлд онцгой анхаарахыг захисан. Тодруулбал, үүргээ шударгаар биелүүлэх, хандалгаа өөрчилж, хариуцлага дээшлүүлэх талаар батлан хамгаалах салбар нэлээд ач холбогдол өгч ажиллаж байна. Сүүлийн үед манай салбарт бага гэлтгүй зөрчил дутагдал гарч байгаа. Бид үүнд дүгнэлт хийх ёстой. Ялангуяа Батлан хамгаалах яам, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, БИЦУГ, нэгтгэл, анги, байгууллагын удирдлагууд анхаарал хандуулж ажиллах ёстой. Тийм учраас энэхүү сургалтад идэвхтэй хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэх нь бидний өдөр тутмын болоод цаашдын үйл ажиллагаанд тун чухал. Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хийж байна. Өнгөрсөн долоо хоногт цэргийн төлөвшил, ёс зүйн талаар нэг цагийн ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулж, телевизийн сувгуудаар олон нийтэд хүргэсэн. Нууцлалын зэрэгтэйгээс бусад асуудалд бид нээлттэй хандах ёстой. Энэ ч үүднээс бид бусад байгууллагатай хамтран ажиллаж байна. Өнөөдрийн сургалт Батлан хамгаалахын сайдын баримталж буй бодлогын хүрээнд явагдаж байгаа. Төрд тангараг өргөсөн төрийн тусгай албан хаагч авлига, ашиг сонирхлоос ангид байх ёстой гэсэн зарчмыг баримтална.

Энэ зарчмын хүрээнд салбарын алба хаагчдад Авлигатай тэмцэх газартай хамтарсан сургалтыг тогтмол зохион байгуулсаар ирсэн. Энэ удаад Батлан хамгаалах яам болон ЗХЖШ-ын Ёс зүйн зөвлөл, АТГ-ын соён гэгээрүүлэх нэгжтэй хамтран сургалт зохион байгуулж, урьд урьдынхаас илүү өргөн бүрэлдэхүүнийг хамрууллаа. Бид авлига, ашиг сонирхлоос ангид байх чадвал салбарын нэр хүнд, алдар гавьяа тэр хэрээрээ өсөн нэмэгдэнэ. Бидний ажлын үр дүнд өмнө нь гарсан алдаа дутагдал, зөрчлүүд арилсан. Гэхдээ сахилга хариуцлага, дэг журмыг улам бэхжүүлэх, үйл ажиллагаагаа төгөлдөржүүлэхэд энэ сургалт чухал ач холбогдолтой. Мөн бид сэтгэлгээ, үзэл санааны хувьд өөрчлөгдөж, тодорхой ахиц гаргаж сургалтын үр дүнг бодитоор мэдрэх ёстой” гээд сургалтад оролцож буй бүрэлдэхүүнд амжилт хүслээ.

Үргэлжлүүлэн АТГ-ын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Н.Батчулуун, М.Жамьянцэцэг нар Авлигын тухай ерөнхий ойлголт, шалтгаан нөхцөл, эрх зүйн орчин, авлига, ашиг сонирхлын зөрчил, түүний хор уршиг зэрэг сэдэв тойрсон олон чухал асуудлыг хөндөж, мэдээлэл өгсөн бол сургалтад хамрагдаж буй бүрэлдэхүүн өөрсдийн сонирхсон асуултад хариулт авч, тодорхой саналуудыг уламжилж байв. 2022 оны нэгдүгээр сараас Батлан хамгаалах яамны харьяа 13 байгууллага, салбарын хэмжээнд удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудад Авлигын эсрэг хууль

тогтоомжийг таниулах, төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагыг зөв байлгах талаар цогц сургалтуудыг хүртээмжтэй зохион байгуулсан бөгөөд энэ удаад ч идэвх оролцоо сайн байгааг Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтнууд мөн дурдсан юм.

Түүнчлэн Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний удирдлагуудын авлига, ашиг сонирхол, ёс зүйн зөрчлөөс ангид байх талаар авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаанаас төрийн албан хаагчийн удирдах манлайлал нэлээд идэвхтэй явагдаж байгаа нь харагдлаа хэмээн онцлов.

ЗХЖШ-ын АУГ-ын дарга бригадын генерал С.Дашзэвэг сургалтыг хааж хэлсэн үгэндээ “Өнөөдрийн сургалтаар та бүхэн мэдээлэл авахын зэрэгцээ харилцан ярилцаж, санал бодлуудаа солилцон, идэвх оролцоогоо нэмэгдүүлээ. Цаашид сургалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх үүднээс холбогдох хууль тогтоомжийг сайтар судлах хэрэгтэй. Бидний хувьд авлига, ашиг сонирхол ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бодлого, үйл ажиллагаагаа улам эрчимжүүлж, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, БИЦУГ болон харьяа нэгтгэл, ангийн удирдлага, бие бүрэлдэхүүн энэ чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлаа тайлагнаж, үр дүнг тооцож ажиллах болно” гээд төрийн албан хаагчийн ёс зүйг ямагт өндөрт өргөж ажиллахыг уриалав.

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
7	-9

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,438	3,443
EUR	3,550	3,580
CNY	481	485
RUB	53.80	54.10
JPY	24.35	24.70
KRW	2.60	2.62

ЗУРХАЙ

2022.11.16 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 23

НАМРЫН АДАГ ЦАГААН НОХИЙ САР ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулбал:

Эд эдлэл идээ ундаа олдоно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

07.59-17.14

БАРИЛДЛАГА:

Рашаан

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Тийн мэдэхүй

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр насны хүч дэлгэрнэ. Эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд төрөл садан бололцох, худалдаа наймааны үйлнээ сайн болой, эм засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нүд татвал тэмцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрмөс татвал үг, асуулт болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 641,073,044

Эдгэрсэн

Нийт: 620,819,259

Нас барсан

Нийт: 6,618,301

ЭНХИЙГ САХИУЛАГЧИД ЭХ ОРОНДОО ИРЛЭЭ



Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй UNMISS ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний мотобуудлагын батальоны 11 дүгээр ээлжийн бие бүрэлдэхүүний эхний ээлж өчигдөр эх орондоо газардлаа.

Энхийг сахиулагчдыг ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг, Энхийг дэмжих ажиллагааны хэлтсийн дарга дэд хурандаа Б.Энхцаг нар угтсан юм. Энэ үеэр бригадын генерал С.Дашзэвэг хэлсэн үгэндээ "Юуны өмнө цагийн байдлын, цар тахлын болон цаг агаарын хүнд нөхцөлд энхийг сахиулах ариун үүргээ нэр төртэйгөөр биелүүлж, монгол төр, цэргийн дээд удирдлагаас

хүлээлгэсэн итгэл, хүндлэлийг амжилттай биелүүлж ирсэн Та бүхэнд баяр хүргэ. Та бүхэн ажиллагааны газар орны хүнд нөхцөлд энхийг сахиулах үүргээ амжилттай гүйцэтгэхийн зэрэгцээ эх орон, Зэвсэгт хүчнээ сурталчлах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулсаар ирсэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Та бүхэн ажиллагааны газар олж авсан дадлага, туршлага, ур чадвараа улам бүр хөгжүүлэн, бусдадаа үлгэр болж ажиллана гэдэгт итгэлтэй байна" гэлээ.

Мөн энэ өдрийн үдэш БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх мотобуудлагын 12 дугаар

ээлжийн батальоны эхний ээлжийн бүрэлдэхүүн ажиллагааны газар орныг зорилгоо.

Бригадын генерал С.Дашзэвэг тэдэнд хандан хэлсэн үгэндээ "Монголын энхийг сахиулагчдын байгуулж ирсэн 20 жилийн нөр хөдөлмөр зүтгэл, алдар гавьяаны үргэлжлэл болон алс холын Африк тивийг зорих гэж байгаа та бүхэнд чин сэтгэлээсээ амжилт хүсье. Монгол цэргийн байгуулж ирсэн гавьяа, хичээл зүтгэлийг улам батжуулж, Монгол Улсын төр, Зэвсэгт хүчнийхээ нэр хүндийг олон улсын тавцанд өндөрт өргөж, үүрэг гүйцэтгэлт, сахилга зохион байгуулалтдаа анхаарч ажиллахыг хүсье. Та бүхнийг Бүх цэргийн Их хар сүлд ивээх болтугай" гэсэн юм.

ШИЛДГҮҮДЭЭ ШАЛГАРУУЛАВ



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 353 ДУГААР АНГИ

2023 оныг "Залуу офицерыг дэмжих жил", "Манлайлын жил" болгосонтой холбогдуулан ангийн үндсэн мэргэжлийн залуу офицер, ахлагч нарын мэргэжлийн болон тактикийн мэдлэг, ур чадвар, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшинг үнэлэхийн зэрэгцээ "Агаарын цэргийн мэргэжлийн аварга офицер, ахлагч шалгаруулах тэмцээн"-д оролцох бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах зорилгоор нийт бие бүрэлдэхүүний дунд "Ангийн мэргэжлийн аварга офицер, ахлагч шалгаруулах тэмцээн"-ийг зохион байгууллаа.

Тэмцээнийг удирдамжийн дагуу

Мэргэжлийн бэлтгэл, Техникийн бэлтгэл, Галын бэлтгэл, Биеийн тамирын бэлтгэл, Химийн нормативын бэлтгэл гэсэн үе шаттайгаар зохион байгуулж алба хаагчид амжилттай хамрагдлаа. Тэмцээний тэргүүн байрт офицеруудаас дэслэгч С.Намсрай, дэд байрт ахлах дэслэгч Д.Эрдэнэжаргал, гутгаар байрт дэслэгч Б.Сүхбат, ахлагч нараас тэргүүн байрт ахлагч Ш.Уртнасан, дэд байрт ахлагч Б.Мөнх-эрдэнэ, гутгаар байрт дэд ахлагч А.Мөнх-Эрдэнэ нар шалгарч "Агаарын цэргийн командлалын мэргэжлийн аварга офицер, ахлагч шалгаруулах тэмцээн"-д оролцох эрхээ авлаа.

АХМАД Б.ГАНЧУЛУУН

ГАР БӨМБӨГ"-ИЙН ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 186 дугаар анги

Ангийн 2022-2023 оны сургуулийн жилийн хөтөлбөр төлөвлөгөөний дагуу алба, тасаг сурталчлах аяны хүрээнд артиллерийн цэргийнхэн мэргэжлээ сурталчлав

Удирдах бүрэлдэхүүний зүгээс "Артиллерийн цэрэг 101 жил" сэдвээр мэдээлэл хүргэсэн бөгөөд хамт олны уур амьсгал, багаар ажиллах чадварыг дээшлүүлэх зорилгоор артиллерчдийн нэрэмжит "Гар бөмбөг"ийн тэмцээнийг зохион байгууллаа. Тус тэмцээнд

ерөнхий цэргийн нэгдүгээр баг тэргүүн байр, хуягт техникийн алба дэд байр, ерөнхий цэргийн хоёрдугаар баг гутгаар байранд тус тус шалгарч бусад нөхдөө манлайлав.

Мөн энэ үеэр 11 дүгээр сард төрсөн 14 байлдагчийн төрсөн өдрийг тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд төрсөн өдрийн эздэд "Сургалтын төв"-ийн хугацаат цэргийн алба хаагчид мэндчилгээ дэвшүүлсэн онцлог үйл явдал боллоо.

Хошууч О.ОТГОНЦЭЦЭГ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 339 ДҮГЭЭР АНГИД...



ТА БҮХНИЙ АМЬДРАЛЫН МАРТАГДАХААРГҮЙ ГЭГЭЭН МӨЧ БОЛОН ҮЛДЭХ УЧИРТАЙ

2022 оны хоёрдугаар ээлжээр Завхан, Говь-Алтай, Өвөрхангай, Баянхонгор аймгуудаас цэргийн албанд татагдан ирж албаа нэр төртэй хааж буй шинэ дайчдынхаа төрсөн өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ.

Арга хэмжээг нээж ангийн захирагч хурандаа Ц.Батхүү хэлсэн үгэндээ, "Хугацаат цэргийн алба хаах хугацаандаа төрсөн өдрөө тэмдэглэж, мөр зэрэгцсэн дайчидтайгаа дурсамж дүүрэн нэгэн өдрийг өнгөрүүлж байгаа нь та бүхний амьдралын мартагдахааргүй гэгээн мөч болон үлдэх учиртай"-г онцлов.

Энэ үеэр төрсөн өдрөө тэмдэглэж буй шинэ дайчдад Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн сургалтын төвийн бие бүрэлдэхүүн болон цэргийн гал тогоо, үлээвэр найрал хөгжмийн хамт олон баярын мэндийг өргөн дэвшүүлэхийн зэрэгцээ ахмад Б.Лувсандан, 3 салааны байлдагч Б. Самбуу, Б.Бямба-даш нар ая дууны мэндчилгээг өргөн бариллаа.



ЁС ЗҮЙ БА ТӨЛӨВШИЛ...

Батлан хамгаалах сайдын дэргэдэх Иргэний зөвлөлийн гишүүд оролцсон "Ёс зүй ба төлөвшил" нэвтрүүлгийг 2022 оны II ээлжээр татагдан ирсэн хугацаат цэргийн алба хаагчид болон мэргэжил олгох сургалтад үүрэг гүйцэтгэж буй офицер, ахлагч нарт үзүүллээ.



"ЭХ ОРОНЧ ЗАЛУУ" СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар-тай хамтран цэргийн насны залууст зөв хандлага, эх оронч хүмүүжлийг төлөвшүүлэх зорилгоор "Эх оронч залуу" сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Эл өдөрлөгт Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга хүүхдийн эрхийн улсын ахлах байцаагч Н.Мэндбаяр, Зэвсэгт хүчний 339 ангийн захирагч хурандаа Ц.Батхүү, алба хаагчид, 2022 оны II ээлжээр татагдан ирсэн шинэ дайчид оролцлоо.

СУРГАЛТ

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №22

МОНГОЛ БИЧГЭЭР УНШИЖ СУРАХ

Монгол бичгээр багахан хугацаанд, түгдрэхгүй уншиж сурах хэрэгцээ эхлэн сурч буй хүн бүрд чухал байдаг. Үүний тулд дараах хэдэн зүйлийг баримталбал цаг алдалгүй амжилтад хүрнэ.

1.Цагаан толгойн бүх үсгээ нүдлэн тогтоосон байх. Үүнд, эгшиг болон гийгүүлэгч үсгийн эхэнд, дунд адагт орох хувилбар, дармал бичмэл тигийн ялгаа, дэвсгэр үсгийн тухайд дэвсгэрлэсэн, үл дэвсгэрлэсэн тохиолдлоор нь таньж чадаж байвал зохино.

2.Тухайн үгийг уншихдаа хүйсийг нь таньж чадаж байвал сайн. Үгийн хүйсийг мэдэхдээ тэргүүн үед нь Э,Ө,У эгшиг орсон бол эм үг, А,О,У эгшиг орсон бол бүхэлдээ эр үг гэж мэддэг. Тэргүүн үедээ И эгшигтэй үгийн хувьд дараагийн үеийг нь харж тогтооно. Монгол хэлэнд, нэг үгэнд эр, эм эгшиг холилдон ордоггүй. Үүнийг "Эгшиг зохицох ёс" гэдэг. Түүнээс гадна, монгол бичигт Х, Г гийгүүлэгч үгийн хүйсийг ялгадаг. Өөрөөр хэлбэл, эр, эм үгийн Х, Г үсэг хэлбэр зурлагын хувьд ялгаатай. Тухайн үгэнд өмнөө 2 дусалтай эр Га орсон бол тэр үг бүхэлдээ эр үг, эм үгийн нуман Х, Г орсон байвал бүхэлдээ эм үг л байна. Эр үгэнд, нэгдүгээр үеэс хойш орсон гэдсийг О юм уу У-гаар, эм үгэнд Ө юм уу Ү-гээр уншина. Эр үгэнд тэргүүн үеэс хойши шүд, орхиц, сүүлийг А-гаар, эм үгэнд тэдгээрийг Э-гээр тус тус уншина.